



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/400

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацаа
сунгах, хаягийн өөрчлөлт бүртгэх, чиглэл цуцлах,
эрх сэргээх, түдгэлзүүлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.2, 10.1.5, 13 дугаар зүйлийн 13.1, 15 дугаар зүйлийн 15.12.2, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2, 19.3.3, 19.3.4, 19.18, 19.20.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Эрүүл мэндийн сайдын 2013 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/400 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, "Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл" олгох комиссын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, чиглэл нэмэх байгууллагын нэрсийг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, эрх сэргээх, хаягийн өөрчлөлтийг бүртгэх байгууллагын нэрсийг хоёрдугаар, тусгай зөвшөөрлийн чиглэлийг хэсэгчлэн цуцлах байгууллагын нэрсийг гуравдугаар, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх байгууллагыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагыг арга зүйгээр хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар (Л.Зэндмаа), Чанарын хяналтын газар (Г.Номин) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422 010202

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2022 оны 10
дугаар сарын 27-ны өдрийн 1/2022 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
1.	Ачит байгаль мед ХХК РД-6732984 9011829807	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	БЗД, 6-р хороо, 13-р хороолол, Энхтайвангийн өргөн чөлөө 86 байр 204 тоот. Улаанбаатар хот	2025.10.26
2.	Бинно ХХК РД-6833896 9011837096	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	Баянгол дүүрэг, 5 дугаар хороо, Энхтайвангийн өргөн чөлөө 93/1 эмнэлгийн байрны 1 болон 5 давхарт. Улаанбаатар хот	2025.10.26
3.	Вита ундарга ХХК РД-6872921 9011839913	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Л.Лааганы 57-р байр, Ү-1 тоот. Улаанбаатар хот	2025.10.26
4.	Сэмбэлхишиг ХХК РД-5905818 9011514059	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо, 7 дугаар хороо, Алтайн гудамж 229 дүгээр байр У-2 тоот. Улаанбаатар хот	2025.10.26

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2022 оны 10
дугаар сарын 27-ны өдрийн 4/802 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАХ, ХАЯГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ
БҮРТГЭХ, ЭРХ СЭРГЭЭХ БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
Нэг. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах байгууллага				
1.	Фарм трейд ХХК РД-52588979 9011169025	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	Чингэлтэй дүүрэг 2-р хороо, жуулчны -50, өөрийн байранд	2027.10.11
2.	Экспресс оношилгооны төв ХХК РД-2807238 9011100002	Оношлуур импортлох, ханган нийлүүлэх	Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо, 12 дугаар хороолол, Энхтайвангийн өргөн чөлөө 25 дугаар байрны 2 дугаар давхрын хэсэг	2027.10.10
3.	Чин баян трейдинг ХХК РД-6424201 9011391095	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	Баянгол дүүрэг, 7 дугаар хороо, 3-р хороолол, ард аюушийн өргөн чөлөө 94 тоот	2027.10.27
4.	Монгол эм импекс концерн ХХК РД-2116847 9011420003	Мансууруулах болон сэтгэц нөлөөт эм импортлох, ханган нийлүүлэх	Сүхбаатар дүүрэг 3 дугаар хороо, их тойрог-39. Улаанбаатар хот	2027.10.16
5.	Мон энзим ХХК РД-2797461 9019097164	Эм, биобэлдмэл үйлдвэрлэх	Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, эв нэгдлийн гудамж 83/1 тоот өөрийн байр	2027.08.17
Хоёр. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, хаягийн өөрчлөлтийг бүртгүүлэх байгууллага				
6.	Брайн бэйс корпорэйшн монголиа ХХК РД-6284833 9011721149	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, залуучуудын өргөн чөлөө гудамж 13 байр нэгдүгээр давхарт	2027.10.25
Гурав. Хаягийн өөрчлөлтийг бүртгэх				
7.	Чодбацо ХХК РД-5234166 9011154117	Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт	Хан- Уул дүүргийн 4 дүгээр хороо, Арцатын ам, наадамчдын зам	2024.11.05

		бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	гудамж, Гарден сити хотхон 1074-р байрны 105 тоот	
Дөрөв. Тусгай зөвшөөрлийн хаягийн өөрчлөлтийг бүртгэх, хугацаа сунгах, эрх сэргээх байгууллага				
8.	Алтан заан эм ХХК РД-6349242 9011759034	Эм импортлох, ханган нийлүүлэх	Баянгол дүүргийн 19 дүгээр хороо, 4-р хороолол, Л.Энэбишийн өргөн чөлөө гудамж 65А байр Б блок 1 давхарт	2027.02.26

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 8/202 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЧИГЛЭЛИЙГ ЦУЦЛАХ
БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Чиглэл цуцлах
Нэг. Тусгай зөвшөөрлийн чиглэлийг цуцлах				
1	Мон энзим ХХК РД-2797461 9019097164	Эм, биобэлдмэл үйлдвэрлэх	Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, эв нэгдлийн гудамж 83/1 тоот өөрийн байр	Тусгай зөвшөөрлийн биобэлдмэл үйлдвэрлэх чиглэлийг цуцлах

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2022 оны 10
дугаар сарын 07-ны өдрийн 11 дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Түдгэлзүүлэх хугацаа
1	Лак лайф их монгол ХХК РД-5749247 9011436001	Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	Баянгол дүүрэг, 7 дугаар хороо, 4-р хороолол, ард аюушийн өргөн чөлөө 73 тоот	3 сар